

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/03/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn
Эрдэнэт хот

2023 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: В.Жавзмаа
Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.03.15 № 88
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Авлагын дансны үлдэгдэлд 28.7 сая төгрөгийн тооцооны үлдэгдлийн баталгааны баримтаар баталгаажаагүй авлага бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос өсөхөд нүүрс, мазут, үндсэн сэлбэг хэрэгсэл, шатах тослох материал нөлөөлсөн ба бараа материалын үлдэгдэлд өртөг нь бодит үнэ цэнээс бага 3.8 сая төгрөгийн техник, технологид нийцэх эсэх тодорхойгүй түүхий эд материал бүртгэлтэй байна.

Шинээр 2,243.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 2,578.9 сая төгрөгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг өөрийн хөрөнгөөр угсарч суурилуулж, Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр 33.3 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 48.6 сая төгрөгийн тавилга эд хогшил акталсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 12,264.3 сая төгрөг болж өссөн ба тооцооны үлдэгдлийн баталгааны баримтаар баталгаажсан байна.

Зардал өмнөх онтой харьцуулахад 16,223.9 сая төгрөгөөр өссөн нь шинэ өргөтгөл ажиллаж эхэлсэн болон дулааны эрчим хүчний түгээлт 11.8 мянган Гкал-аар нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Аудитын гол асуудал

Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хөнгөлөлттэй зээлээр барьсан хүчин чадлыг 35 МВт-аар өргөтгөх 126,286.5 сая төгрөгийн өргөтгөлийн ажил дуусаж, улсын комисс хүлээн авч, ашиглаж эхэлсэн боловч хөрөнгийг бүртгэх, зээлийн төлөлтийн талаарх шийдвэрийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар гаргаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Эрчим хүчний сайдын 2022 оны А/28 дугаар тушаалаар Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 58,879.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 71,556.0 сая төгрөгөөр, 12,676.8 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоож, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 10,735.1 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Эрчим хүчний сайдын 2022 оны А/189 дүгээр тушаалаар Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг тодотгохдоо нийт орлогыг 784.0 сая төгрөг нэмж, нийт зардлыг 607.6 сая төгрөг, алдагдлыг 1,391.6 сая төгрөг, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 305.5 сая төгрөгөөр тус тус бууруулж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 62,860.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 66,192.3 сая төгрөгийн зардал гарган, 3,661.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 3 нэр төрлийн 136 ажилд өөрийн эх үүсвэрээс 10,182.5 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж, 96 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
А	А	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	309,549,506.35	75,553,004.77
1.1.2	Дансны авлага	5,709,058,428.32	3,409,265,747.37
1.1.3	Татвар НДШ-ийн авлага	-	190,735,139.18
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	2,402,190,286.39	3,360,728,133.81
1.1.7	Урьдчилж төлсөн зардал /тооцоо/	1,032,387,487.05	1,702,649,033.98
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Эргэлтийн хөрөнгийн дүн	9,453,185,708.11	8,738,931,059.11
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	63,262,732,758.52	67,292,432,000.82
1.2.2	Биет бус хөрөнгө	21,116,509,267.61	21,125,404,933.43
1.2.3	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.4	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.5	Хойшлогдсон татварын хөрөнгө	171,009,003.10	-
1.2.6	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.7	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	84,550,251,029.23	88,417,836,934.25
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	94,003,436,737.34	97,156,767,993.36
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,907,792,482.39	9,355,467,419.71
2.1.1.2	Цалингийн өглөг	-	33,356,877.85
2.1.1.3	Татварын өр	163,784,593.69	500,064,657.98
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүгийн өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	352,496,872.21	108,495,906.24
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	288,826,158.76	2,266,885,154.61
2.1.1.11	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,712,900,107.05	12,264,270,016.39
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.3	Татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	4,106,806,471.32	1,397,443,924.72
2.1.2.5	Урт хугацаат өр төлбөрийн дүн	4,106,806,471.32	1,397,443,924.72
2.2.20	ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	6,819,706,578.37	13,661,713,941.11
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.1	Өмч: а) төрийн	19,447,456,792.53	19,447,456,792.53
2.3.2	б) хувийн	-	-
2.3.3	Хувьцаат өр төлбөр	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	59,135,050,898.37	59,135,050,898.37
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	20,937,713,000.00	20,937,713,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(12,336,490,531.93)	(16,025,166,638.65)
2.3.10	Эздийн өмчийн дүн	87,183,730,158.97	83,495,054,052.25
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	94,003,436,737.34	97,156,767,993.36

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12 -р сарын 31
1	Борлуулалтын орлого /цэвэр/	48,429,590,764.60	61,343,644,109.51
2	Борлуулалтын өртөг	44,654,776,481.71	60,512,421,055.00
3	Нийт ашиг (алдагдал)	3,774,814,282.89	831,223,054.51
4	Түрээсийн орлого	36,896,083.09	36,591,051.00
5	Хүүгийн орлого	3,320,043.14	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	1,559,102,984.47	1,480,019,954.67
9	Борлуулалт, маркетингийн зардал	3,909,124,979.60	4,058,537,879.83
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,208,438,832.13	1,416,191,327.27
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	196,095,695.75	205,088,963.13
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулалтаас үүссэн олз /гарз/	-	-
17	Бусад ашиг /алдагдал/	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	60,473,886.11	(3,331,984,110.05)
19	Орлогын татварын зардал	6,379,392.92	329,641,996.67
20	Татварын дараах ашиг /алдагдал/	54,094,493.19	(3,661,626,106.72)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	54,094,493.19	(3,661,626,106.72)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз /гарз/	-	-
24	Орлогын нийт дүн	54,094,493.19	(3,661,626,106.72)
25	Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000.00	(12,309,060,582.56)	87,211,160,108.34
Залруулсан үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000.00	(12,309,060,582.56)	87,211,160,108.34
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	(81,524,442.56)	(81,524,442.56)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	54,094,493.19	54,094,493.19
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000.00	(12,336,490,531.93)	87,183,730,158.97
Залруулсан үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000.00	(12,336,490,531.93)	87,183,730,158.97
Зарласан ногдол ашиг	-	-	-	27,050,000.00	27,050,000.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(3,661,626,106.72)	(3,661,626,106.72)
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000.00	(16,025,166,638.65)	83,495,054,052.25

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	45,372,062,749.31	59,561,213,989.20
1.1.1.	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	45,225,456,359.02	59,490,799,321.76
1.1.2.	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3.	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4.	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5.	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6.	Бусад мөнгөн орлого	146,606,390.29	70,414,667.44
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(43,318,724,601.00)	(54,904,513,281.10)
1.2.1.	Ажиллагчдад төлсөн	(9,286,234,756.50)	(10,849,720,805.00)
1.2.2.	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(3,246,727,644.86)	(3,666,983,347.27)
1.2.3.	Бараа материал худалдан авахад төлсөн	(17,078,258,714.46)	(18,158,619,128.19)
1.2.4.	Ашиглалтын зардалд төлсөн	(1,453,671,545.21)	(2,275,147,212.00)
1.2.5.	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(9,817,039,701.11)	(17,055,212,141.23)
1.2.6.	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
1.2.7.	Татварын байгууллагад төлсөн	(2,293,050,166.19)	(2,764,968,159.01)

1.2.8.	Даатгалын төлбөрт төлсөн	(9,920,985.19)	(8,442,687.61)
1.2.9.	Бусад мөнгөн зарлага	(133,821,087.48)	(125,419,800.79)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,053,338,148.31	4,656,700,708.10
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,253,082.01	-
2.1.1.	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2.	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3.	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4.	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5.	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6.	Хүлээн авсан хүүгийн орлого	3,253,082.01	-
2.1.7.	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(2,724,928,964.54)	(4,890,697,209.68)
2.2.1.	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(2,722,128,964.54)	(4,822,754,772.01)
2.2.2.	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(2,800,000.00)	(67,942,437.67)
2.2.3.	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,721,675,882.53)	(4,890,697,209.68)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1.	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2.	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3.	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4.	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(81,524,442.56)	-
3.2.1.	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
3.2.2.	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3.	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	-	-
3.2.4.	Төлсөн ногдол ашиг	(81,524,442.56)	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(749,862,176.78)	(233,996,501.58)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,059,411,683.13	309,549,506.35
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	309,549,506.35	75,553,004.77

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2021 оны				
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
1	Үйлдвэрлэсэн: ЦЭХ		сая.квтц	271.0	434.5	427.1	(7.4)	100.1
	Үйлдвэрлэсэн: ДЭХ		мян.Гкал	657.8	680.9	692.7	11.8	
	Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим	Хувиар	хувь	14.85	13.59	13.59	0	
		Биетээр	сая.квтц	40,3	59.1	58.1	(1.0)	
	Түгээсэн: ЦЭХ		сая.квтц	230.8	375.4	369.1	(6.4)	
	Түгээсэн: ДЭХ		мян.Гкал	616.0	637.2	641.5	4.4	
2	Нийт орлого		сая.төг	50,028.9	59,663.2	62,860.0	3,197.0	105.4
	Үүнээс:	Цэвэр борлуулалт	сая.төг	48,429.6	58,195.7	61,344.0	3,148.0	
		Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	1,599.3	1,467.5	1,516.6	49.1	
3	Нийт зардал		сая.төг	49,968.4	70,948.4	66,192.3	(4,756.1)	107.2
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	сая.төг	49,772.3	70,568.0	65,987.2	(4,580.8)	
		Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	196.1	380.4	205.1	(175.3)	
4	Татварын өмнөх ашиг/алдагдал		сая.төг	60.5	(11,285.2)	(3,332.3)	7,952.9	100.0
5	Татварын дараах ашиг/алдагдал		сая.төг	(6,319.0)	(11,285.2)	(3,661.6)	7,623.6	100.0
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал		төг	1.0	1.2	1.05	(0.15)	112.9
7	Нийт авлага		сая.төг	5,709.1	6,107.6	3,600.0	(2,507.6)	100.0
	Үүнээс:	ЭХ-ний	сая.төг	5,705.5	6,097.6	2,671.7	(3,425.9)	
		бусад	сая.төг	3.5	10.0	928.3	918.3	
8	Нийт өглөг		сая.төг	6,819.7	170,015.6	13,661.7	(156,353.9)	100.0
	Үүнээс:	БХӨТ	сая.төг	2,712.9	23,880.3	12,264.3	(11,616.0)	
		УХӨТ	сая.төг	4,106.8	146,135.3	1,397.4	(144,737.9)	
9	Нийт ажиллагсдын тоо		хүн	450	461	461	0	100.0
10	Нийт цалингийн сан		сая.төг	11,617.7	13,531.2	13,510.0	(21.2)	100.0
11	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	ЦЭХ	гр/кВт.ц	368.4	441.2	415.4	(25.8)	103.5
		ДЭХ	кг/Гкал	187.6	185.8	184.4	(1.4)	
12	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт		сая.төг	5,163.3	10,429.6	10,182.5	(247.1)	96.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын явцад алдаа¹ залруулж, бүртгээгүй болно.

Аудитаар нийт 7,008.9 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 14.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 6,894.8 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 99.8 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Бүтээмжийн ажлын урамшууллыг тухайн ажлын үр дүн, үр ашиг тодорхой бус, бодит хэмнэлт үүсгэснийг тодорхойлохгүйгээр олгосон, төмөр замын мэргэжил шаардсан албан тушаалд ерөнхий шаардлага, шалгуур хангаагүй ажилтан ажиллуулж, тэдгээрийг мэргэшүүлэх сургалтын зардлыг компаниас төлсөн зэрэгт төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй авлага бүртгэж тайлагнасан, ажлын байрны тодорхойлолтод заасан шалгуур хангаагүй ажилтныг албан тушаалд томилон ажиллуулж, ажлын байрны тодорхойлолтын ерөнхий шалгуурыг харилцан адилгүй баталсан, Олон улсын мэргэжлийн хөгжлийн институт НҮТББ-тай ажил гүйцэтгэх 20.0 сая төгрөгийн гэрээг 2022.05.16-нд байгуулж зардал хэмнээгүй, бичиг хэргийн зардал өмнөх оноос нэмэгдүүлж, бичгийн цаас 30, принтерийн хор 54-өөр өсгөж, хэмнэлтгүй зарцуулсан, нийт өр төлбөрийг 6,842.0 сая төгрөгөөр өсгөсөн зэрэг асуудлуудад албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өр төлбөрийн тооцооны үлдэгдлийн баталгааны хавсралт болох тооцооны баримтын жагсаалтыг үйлдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 3-т "Харилцагч талуудын хооронд гарсан ажил гүйлгээг тодруулан тайлант үеийн эцэс дэх хоорондын тооцооны үлдэгдлийг баталгаажуулахдаа улирал, жилийн эцэст харилцагч талуудын тооцооны үлдэгдлийн баталгааг үйлдэнэ. Шаардлагатай бол санхүүгийн тайлангийн дундуур хийж болно. Тооцооны үлдэгдлийн баталгааг тооцоо үүссэн данс бүрээр хөтөлнө. 2 байгууллагын тооцооны баримтыг тооцооны үлдэгдлийн баталгааны хавсралтад нэгтгэж гаргана" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өр төлбөрийн тооцооны үлдэгдлийн баталгааг заавар, аргачлалд заасан баримтын дагуу иж бүрэн хөтөлж, баталгаажуулж, данс бүртгэлд тусгах.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлд тоо хэмжээгүй, өртөг бодит үнэ цэнээс бага байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", НББОУС 2-Бараа материалын 2.9-д "бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар үнэлнэ", "Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн бодлого, суурь, зарчим, тэдгээрийн өөрчлөлтийн талаар заавал нэмж тодруулах шаардлагатай. Бараа материалын хувьд баланс болон орлогын тайланд тусгагдсан бүхий л дүнг тодруулах шаардлагатай" гэж заасантай нийцэхгүй, аудитын үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын ашиглалтын нөхцөл байдлыг тодорхойлж, холбогдох шийдвэрийг гаргуулан, стандартад нийцүүлэн бүртгэж, тайлагнах.

Илрүүлэлт: Их засвараас гарч буй ашиглаж болох түүхий эд материалын орлого, зарцуулалтыг тодорхой тайлагнаагүй, бодитой оршин байгаа үлдэгдлийг тоолж, бүртгээгүй байна. Энэ нь ЭДЦС ТӨХК-ийн үндсэн ба туслах тоноглолын их засвар, ТЗБАХ-ээр хийгдэх ажилд хяналт тавих журмын 4.6-д "Тоног төхөөрөмжийн их засварын явцад гаднын байгууллага, хувь хүнээс шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг материалыг худалдан авч ашиглахдаа "ЭДЦС ТӨХК-ийн материал сэлбэг, тоног төхөөрөмж, машин механизм худалдан авах журам"-ыг мөрдлөг болгон ажиллах бөгөөд их засварын үед шинээр тавьж байгаа сэлбэг материал, тоног төхөөрөмж болон солигдсон хуучин эд анги, тоног төхөөрөмжийг хяналтын инженерүүдэд шалгуулж шийдвэр гаргуулна", 4.8-д "Шинээр тавьсан эд анги, тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх, хуучин эд, анги тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасаж актлах бүртгэж, өөрчлөлт хийснээс хойш 3-5 хоногийн дотор цехийн дарга, СЭЗХ-ийн үндсэн хөрөнгийн нягтлан бодогч нар хамтран зохион байгуулна" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компанид мөрдөж буй журмын дагуу тооцоог хөтөлж, бүртгэлд тусгах.

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үлдэх өртөггүй 1357 нэр төрлийн үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоолоогүй, холбогдох шийдвэр гаргаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, аудитын үнэлгээ ба хуваарилалт, тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үлдэх өртөггүй 1357 нэр төрлийн үндсэн хөрөнгийн ашиглах жилийг тогтоон, дахин үнэлэх шийдвэр гаргуулж, холбогдох стандартад нийцүүлэн бүртгэж, тайлагнах.

4. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Техник хяналтын зардлыг инженерүүдэд олгохдоо хяналт хэрэгжүүлсэн нөхцөл байдлыг хэрхэн үнэлсэн талаар тодруулга, тайлбар шийдвэргүй олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", ЭДЦС ТӨХК-ийн үндсэн ба туслах тоноглолын их засвар, ТЗБАХ-ээр хийгдэх ажилд хяналт тавих журмын 4.13-т "ТЗБАХ, үндсэн, туслах тоноглолын их засварын хугацаанд техникийн хяналт тавьсан хүмүүст засварын ажлын чанар, засварын хугацаанд хийж гүйцэтгэсэн үүргийг харгалзан үзэж төсөвт тусгагдсан техник хяналтын зардлыг "Төсөв хийх, хяналт тавих, урамшуулал олгох тухай журам"-ын 5.9, 6.9, 7.5, 7.6-н заалтын дагуу гүйцэтгэх захирлын тушаалаар олгоно" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компанид мөрдөхөөр баталсан үндсэн болон туслах тоноглолын их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээгээр хийгдэх ажилд хяналт тавих журмыг бүрэн мөрдөж, зарцуулах шийдвэргүйгээр техник хяналтын зардал олгохгүй байх.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЭДЦС ТӨХК												
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЭДЦС ТӨХК	7	135.0	1	10.3	1	28.7	5	99.8				
Дүн	7	135.0	1	10.3	1	28.7	5	99.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ЭДЦС ТӨХК								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЭДЦС ТӨХК	7	6,870.1	1	4.0	4	6,866.1	2	
Дүн	7	6,870.1	1	4.0	4	6,866.1	2	
Нийт дүн	7	6,870.1	1	4.0	4	6,866.1	2	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
6	ТБОНӨААН	1	1			1			
	НИЙТ	1	1			1			